

Орон бүхний пролетарийн нар нэгдэгтүн!

АНХ ДЭГТЭЭР

ТАВАН ЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргааны сонин

26 дахь
жилдээ

№ 32 (2296)

1974 оны 4 дүгээр сарын 25

ПҮРЭВ

Уралдаан дүгнэв

Дэлгэрхаан, Бүрэн сумд 1974 оны социалист уралдаанд харилцан авсан үүрэг амлалтынхаа I улирлын дүнг Бүрэн сумын төвд гаргав.

Социалист уралдаанд авсан үүргээ 22 үзүүлэлтээр дүгнэхэд төл бойжуулалт, малын зүй бусын хорогдол, соёл үйлчилгээний байгууллагуудын төлөвлөгөөний биелэлт зэрэг гол 14 үзүүлэлтээр Дэлгэрхаан сум I улирлын социалист уралдааны түрүүг авав.

МАНАЙ СУРВАЛЖЛАГЧ

МАЛ АЖ АХУЙН ХЭСЭГ

Мал аж ахуйн хэсэг байгуулан ажиллуулах нь хөдөлмөрийн зохион байгуулалтыг сайжруулж, удирдлагыг үйлдвэрлэлд ойртуулах ашигтай хэлбэр болохыг манай орны тэргүүний нэгдлүүдийн туршлага хариуцж байна.

Аймгийн Намын хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас нийт нэгдлүүдэд хэсгийн систем нэвтрүүлэх талаар гаргасан шийдвэрийг биелүүлэхийн тулд Баянцагаан, Дэлгэрхаан, Баянзүрх зэрэг сум-нэгдлүүд нилээд ажил зохиож байгаа боловч зарим нэгдэлд уг ажил эхлээгүй буюу удаашралтай явагдаж байна.

Мал аж ахуйд хэсгийн систем нэвтрүүлэх ажлыг нэгдлийн үйлдвэрлэлийн байршил, байгаль эдийн засгийн онцлог, ажиллах хүчний бололцоог харгалзан үзсний үндсэн дээр төлөвлөгөө график гарган, түүний зорилго, ач холбогдлыг нэгдлийн гишүүдэд сурталчлан ойлгуулж малчид нэг бүрийн санал хүсэлтийг авч зохицуулах нь зүйтэй.

Хэсэг байгуулан ажиллаж байгаа туршлагаас үзэхэд мал аж ахуйн хэсэгт нэгдлийн гол үйлдвэрлэл соёл хүмүүжлийн бүх ажил хэсэгт төвлөрч байгаагийн дээр худаг ус гаргах, хашаа хороо барих, өвс хадлан бэлтгэх, мал ноослох, алсын отор хийх, сүү сааль бэлтгэх зэрэг нэг суурийн хүчээр гүйцэтгэхэд төвөгтэй хүнд ажлыг хэсгийн хүмүүсийн нэгдсэн хүчээр богино цагт хийх боломжийг олгодог.

Мал аж ахуйн бригадалд 8-10 хэсэгтэй байхаар зохион байгуулж, хэсгийн эзэмших жилийн дөрвөн улирлын ба отрын бэлчээр, хадлангийн талбайг нарийвчлан тогтоож мал, хашаа, худаг, үйлдвэрлэлийн багаж хэрэгсэл зэрэг үндсэн ба эргэлтийн хөрөнгийг актаар эзэмшүүлж, ахлагчаар нь амьдралын дэдлага, туршлага бүхий олон түмэндээ нэр хүндтэй тэргүүний хүмүүсийг сонгон тавьж ажиллуулах хэрэгтэй.

Сүүлийн үед зарим газарт хэсгүүдийн өдөрлөг зохион байгуулдаг зөвхөн арга хэлбэр нэвтэрч байна. Мөн СХ-ийн хөдөлгөөнийг мал аж ахуйн хэсгийн зохион байгуулалттай нягт холбож байгаа нь аж ахуйн зорилтыг амжилттай биелүүлэх, хөдөлмөрийн хамт олныг хүмүүжүүлэх чухал хэлбэр болж байна. Ийм учраас сумын нам, улсын байгууллагаас СХ-ийн ба СХТ хэсгийг байгуулж бэхжүүлэх явдалд онцлон анхаарч ажиллавал зохино.

Социалист уралдаан суурийн хэмжээгээс хальж хэсгүүд уралдааны үүрэг авч хамт олноороо урлах хөдөлгөөн өрнөж байгаа нь СХ-ийн хамт олон, хэсгийн малчдын хамтач ажиллагааг сайжруулж хоцрогсдыг өөд татахад чухал хүчин болж байгаа болон хэсгийн айлуудыг өргөн айлсалтын журмаар нэг газарт төвлөрүүлж мал сүргээ оторт гаргаж, ар гэрийн хүмүүсийг зохион байгуулан ажиллуулдаг туршлагыг өргөн нэвтрүүлвэл зохино.

Хэсгүүдийг аж ахуйн тооцооны үндсэн дээр ажиллуулж үйлдвэрлэлийн даалгаврыг тооны үзүүлэлтээр өгөхөөс гадна шууд зардлын лимит, цалингийн хэмжээ, зардал хэмнэх, төлөвлөгөө биелүүлсэн болон давуулснаас авах шагналт ба нэмэгдэл хөлс, үйлдвэрлэх, борлуулах бүтээгдэхүүн зэргийг тодорхой тооцон өгч хүн нэг бүрт сурталчлан тэдний идэвх хөдөлгөөнийг өрнүүлэх хэрэгтэй.

Сумын нам, захиргааны байгууллагаас хэсэгт удирдлагыг төвлөрүүлж, хэсгийг сумын намын үүр, хорооны товчоо, АДХ-ын гүйцэтгэх захиргааны гишүүдэд жилээр хариуцуулж, үйлдвэрлэлийн үр дүнг хагас бүтэн жилээр цуваагаар байр эзлүүлэн дүгнэж байвал зохино.

Хэсэг хариуцсан удирдах хариуцлагатан, ухуулагчид хэсэгтээ тогтвортой ажиллаж суурь хэсгийн соёл хүмүүжлийн ажил, хэвлэл тараалт, хэсгийн өдөрлөг, суурийн туршлагын сургуулийг зохион байгуулан удирдах нь зүйтэй.

ЧУУЛГА УУЛЗАЛТЫН УРИАЛГЫН ХАРИУД ХАМТЫН ТООЦООТОЙ БРИГАД

Зуунмод хотын их дэлгүүрийн Долгор ахлагчтай I дүгээр заалын хамт олон хамтын тооцоотой бригадаар эл хариуцах шинэ дэвшилтэд аргыг өөрсдийн ажилдаа нэвтрүүлж байна.

Энэ шинэ хэлбэр нь социалист өмч хөрөнгөнд хамт олны хяналтыг хүчтэй болгож, хамтран эд хариундагаараа онцлогтой юм.

Нэгэнт хамтын тооцоотой учраас өвчтэй, цөлөөтэй, амралттай хүнийхээ оронд аль байгаа худалдагч нь тасаг дамжин үйлчилдэг нь эзгүй байгаа тасгийн төлөвлөгөө тасардаггүй ба оронд нь худалдагч авч ажиллуулах, барааг тоолж хүлээлцүүлэх, тооцоог нь бодох зэргээр хэд хэдэн өдөрөөр хөдөлмөрдөд үйлчлэх цагийг гардаж гүйлгээ алдах явдлыг арилгасан байна.

Мөн хүмүүсийг хамтын

үзэл санаагаар хүмүүжүүлэх, бие биеэ бүрэн итгэх, хамт олны өмнө хариуцах хариуцлагыг өндөржүүлэхэд чухал ач холбогдолтойн дээр хөдөлмөрдийг хөнгөн шуурхай үйлчлэх зорилгоор цуваа график нэвтрүүлэн зарим саруудад үйлчлэх хугацааг уртасган 7 хоногт 50-иад цагаар нэмэгдүүлэн ажиллаж болдог нь заал ашиглалтын коэффициентийг үлэмж дээшлүүлж, борлуулалтын төлөвлөгөөг давуулан биелүүлэх боломжтой байна. Энэ заалын 4 худалдагчийн I сарын тооцоог бодоход 16 цаг зарцуулж байсан бол ахлагч нь хариуцан бодуулдаг болсноор дөнгөж 4 цаг зарцуулж бүртгэлийн ажилтны бүтээлч цагийг 4 дахин хэмнэж хянах шалгах ажилд бусад цагаа зарцуулах бололцоо олгож байна.

Дэвшилтэд энэ хэлбэр

рийг хэрэглэсний үндсэн дээр Долгор ахлагчтай заал нь хүнсний барааны 20 хувийг савлан худалдаалах ажлын хэмжээг нэмэгдүүлж хөдөлмөрдөөс урьдчилан захиалгаа авч үйлчлэх тасаг шинээр нээн үйлчилгээний чанарыг байнга дээшлүүлж ажлын байрны соёл гоо зүйг сайжруулах, 2000-гаас доошгүй хүний эрэлт хүсэлтийг судлан чанарын шаардлага бүрэн хангасан бараагаар үйлчлэх зэрэг үүргүүдийг социалист уралдаанд авчээ.

Энэ заалын худалдагчид МАХН-ын III их хурал, БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ойг угтаж 1810 мянган төгрөгийн жилийн бараа гүйлгээний төлөвлөгөөг 30 хоногийн өмнө 4 хувиар буюу 72,4 мянган төгрөгөөр давуулан биелүүлэхээр үүрэг аваад ажиллаж байна.

Н.ДАГВА

ОЛНЫ ХҮЧ ОЛОМГҮЙ ДАЛАЙ

В.И.Лениний мэндэлсний 104 жилийн ойд зориулсан бүх нийтийн субботник аймгийн төв, хөдөөд өрнөлтэй явагдлаа.

Ням гаригийн өглөө болоход уулын тагт хөрөө сүхний дуу хангинаж, төв суурийн газарт алх дөшний дуу харшин өглөөний 8 цагтай зэрэгцэн төвш дүүрэн ачаатай машинчууд бие биетэйгээ уралдан давхиж, багаж хэрэгсэлээ базаасан албан хаагчид хэдийнэ мэргэлийн ажилчид шиг цаг мөчтэй өрсөлдөн хөдөлмөрлөж эхэллээ.

Зүүн дэлгэрт ҮЭ-н й н

зөвлөл, УААУ газар, Барилга угсралтын контор, Банкныхан чулуу кублэж байв. Аймгийн өвсний фондын хашаанд мал эмнэлэг, цаг уурынхан өвс нуруулдаж, боож багсар, мал тэжээл савлаж байхад Сэргэлэн сумын ХБ ангийн агуулахын барилгыг шүүх, прокурорынхон барьж байв. Холбооны хон хашаа, саравч, агуулах барьж Эрчим хүчний хэн Зам ашиглалтын ангийн шугам сүлжээг шинэчлэн тавив. Ер хаа ч зүгээр байгаа хүн алга.

Тэдний хэнтэй нь ч уулзсан өдрийнхөө төлөв

лөгөөг давууллаа. Үүрэг амлалтаа биелүүллээ.

Бүх нийтийн субботникний өдөр зарласан «Социалист уралдаанд хошуучилж явна» гэж ам дүүрэн хариулах ажээ.

Энэ өдөр Зуунмод хотын хэмжээгээр 42 байгууллагын 3400 гаруй хүн бүх нийтийн субботникт оролцож, 32,7 мянган төгрөгийн ажил хийж, 17,8 мянган төгрөгийг хуримталын фондод оруулж, 14,5 мянган төгрөгийг хот орон сууц, орчин тойроноо тохижуулахад зориулан нөөцөлжээ.

Б.ТОГООХУУ



Аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны хамт олон субботник хийж байгаа нь. Зохиогчийн авсан гэрэл зураг

ХУДАЛДААНЫ БАЙГУУЛЛАГЫН ӨНӨӨГИЙН ЗОРИЛТ

(Аймгийн Намын хорооны төлөөлөгч гишүүн,
ХБУ газрын дарга Д. ГОНЧИГ)

Худалдаа бэлтгэл, нийтийн хоолны системийн хамт олон социалист уралдаанаар жүжүүлэн ажилдаж V таван жилийн төлөвлөгөөний эхний 3 жилийн бараа, ном борлуулалтын төлөвлөгөөг 2,3 хувь буюу сая гаруй төгрөгөөр давуулаа.

1973 оны бараа, номын төлөвлөгөөг 19 сум, нийтийн хоолны бүх газар жигд биелүүлэв.

Мал мах, адуу, тарвага, арьс бэлтгэлийн ажлыг жигд биелүүлж, ноос бэлтгэлийг 16 сум давуулж Батсүхэр, Баянчандмань, Борнуур, Заамар Угтаал сум төрөл бүр дээр нь биелүүлжээ.

ХБУГ-ын хэмжээгээр 24 байгууллагын 852 хүн уралдаанд тооцоотой үүрэг авч ажиллаж байгаагийн дотроос нийт худалдагч нарыг хамтын тооцоотой дэлгүүрийн Долгор ахлагчтай худалдагчид, нийт тогооч нарыг Баянчандмань, гуанзны тогооч, аймгийн аварга Ногосон, бэлтгэлийн эрхлэгч нарыг МАХН-ын гишүүн, Алтанбулаг сумын ХБА-ийн бэлтгэлийн эрхлэгч Буд нар социалист уралдаанд уриалж үүрэг аваад ажиллаж байна.

Ийм эх оронч хөдөлгөөн байвч худалдааны нилээд байгууллагуудын ажил шаардлагаас хоцорч байна.

1973 онд Баянцагаан,

Баян-өнжүүл, Баянцогт, Алтанбулаг сумдын ХБ-ийн ангиуд бараа борлуулалтын төлөвлөгөөг 2,1-2,48 хувиар, Баянжаргалан, Баянцогт, Бүрэн сум ном борлуулалтын 14,5-38,5 хувиар, Бүрэн, Мөнгөнморьт, Баянзүрх, Лүн, Баян, Дэлгэрхаан, Баянцагаан сумд ноос бэлтгэлийн төлөвлөгөөг 13,9-19,2 хувиар тасалдуулсны урсгаар тус аймгаас төлөвлөгөөт ноосоо 22 тоноор таслав.

Агент худалдагч нарын ажиллагаа жигд биш тэдгээрийг удирдах удирдлага суд, социалист уралдааныг хүн нэг бүрийн ажиллагаанд жигд өрнүүлэггүй байна. Бүрэн, Баян-өнжүүл, Баянцагаан сумдын ХБА-ийн олонх ажилчинд төлөвлөгөөт ба уралдаанд авсан үүргээ өнгөрсөн онд биелүүлэггүй бөгөөд системийн дүнгээр 139 хүн уралдаанд авсан үүргээ хангалтгүй биелүүлж ашигт ажиллагааны төвшинг бууруулж ашгийн төлөвлөгөөг Баян-өнжүүл, Баяндэлгэр, Баянцагаан, Баянчандмань зэрэг 12 сумын ХБА тасалсан байна.

Ниймээс өнгөрсөн оны ажилдаа дүгнэлт хийж 1974 онд урьдах 3 жилд дутуу биелүүлсэн зүйлээ нөхөх арга хэмжээ авалхын хамт угтвар төлөвлөгөөг боловсруулан ба-

талж жилийн төлөвлөгөөт үүргийг 35 хоногийн өмнө биелүүлэх хөдөлгөөнийг ХБА-ийн агент, худалдагч нарын дунд өрнүүлвэл зохино.

Өөрөөр хэлбэл 12 дугаар сард бэлтгэх бэлтгэлийн зүйлээс бусад жилийн төлөвлөгөөт бараа, ном, нийтийн хоолны гүйлгээ, мал, адуу, ноос, тарвага, зурамын арьс зэрэг бэлтгэлийн зүйлүүдийг 11 дүгээр сарын 26-ны өмнө бүрэн биелүүлж ашигт ажиллагааг хангахаар хүн бүрийн бүтээлтэй санаачилга, мэдлэг, авьяасыг өрнүүлэн, бүхий л ноон болонхоогоо дайчлан угтвар төлөвлөгөөг зохиож ажиллах нь чухал байна.

Үүнтэй холбогдуулж үйлдвэр үйлчилгээний газар, байгууллагуудын ажлын уялдаа, хөдөлмөрийн зохион байгуулалтыг эрс сайжруулж, машины техник, тоног төхөөрөмжийн хүч чадлын ашиглалтыг өнгөрсөн онхоос 10-аас доошгүй хувиар нэмэгдүүлэн ажлын цагийн алдагдлыг эрс багасгаж, бэлтгэлийн зүйлийн чанарын алдагдлыг 1973 оныхоос 50-аас доошгүй хувиар хорогдуулан 1, 2 дугаар зэрэгт хүргэх, чанарын төвшинг арьс, ширэнд 70, 80 хувь, ямааны ноолуур, тарваганы арьсанд 85-90 хувьд хүргэж, бэлтгэсэн таван төрлийн зөөлөн ноосыг 100 хувь преслэн, машины даан ашиглалтыг нэмэгдүүлэн тээвэрлүүлэх дэвшилт зорилтыг бүрэн хэрэгжүүлэх нь чухал.

1974 оны 1 дүгээр улирлын төлөвлөгөөний дутууг 2 дугаар улиралд нөхөн, хагас жилийн төлөвлөгөөг 23 хоногийн өмнө биелүүлэхэд уралдааны арга хэлбэрийг чиглүүлбэл зохино.

ҮЭ-ИЙН НИЙТ БҮЛГҮҮДИЙГ УРИАЛЖ АВСАН ҮҮРЭГ

Аймгийн ҮЭ-ийн зөвлөлийн бага хурал, МҮЭ-ийн Төв Зөвлөлөөс ҮЭ-ийн бүлгийн ажиллагаанд хийх үзлэг угтаж НААУГ-ын дэргэдэх ҮЭ-ийн 5 дугаар бүлгийн хамт олноос аймгийн ҮЭ-ийн нийт бүлгүүдийг уриалж авсан үүргийг дор нийтлэв.

Бүлгийн хурлыг тогтмолжуулан оновчтой асуудал хэлэлцэн гарсан шийдвэрийн биелэлтийг дүгнэж дараагийн хуралт тайлагнаж байна.

Идэвхтний ажлыг тогтмолжуулан тэдний ажлыг сар бүр цуваагаар дүгнэнэ.

Социалист уралдаанд ажилчин бүрийг тооцоотой үүрэг авахуулж үүргийн биелэлтийг өдөр, сар, улираар дүгнэн цуваагаар байр эзлүүлж байна.

Ажлын уялдаа, холын боотой тасаг бригадын хамт олон, хүмүүсийн хооронд уралдааны гэрээ байгуулан ажиллана.

Үйлдвэрийн байнгын зөвлөлтөөн, хамтын гэрээгээр тасаг, бригад, хэсэгт өгөгдсөн үүргийг тухай бүр биелүүлнэ.

Гишүүн бүр үйлдвэрлэлийн төлөвлөгөөг 01-10 хувиар давуулж тасгийн жилийн төлөвлөгөөг 30 хоногийн өмнө биелүүлнэ.

Дотоодын нөөц болонхоог илрүүлж ашиглах замаар хүн бүхэн 10 төгрөгийн хуримтлал оруулна.

Ажлын цагийн алдагдлыг багасгах, олон нийтийн үзлэг шалгалтыг явуулж өвчлөлөөс бусад цагийн гарздыг бүрмөсөн арилгана.

Тасаг, цехээрээ СХ-ийн хөдөлгөөнд хамрагдана.

ҮЭ-ийн байгууллагуудын ажлын туршлагаас

3-ыг ажиллаа нэвтрүүлнэ.

Хөдөлмөрийн шийнэ хуулийг ажилчин, албан хаагчдад тайлбарлан таниулж, чанг хэрэгжүүлэн, биелэлтэнд нь байнгын хяналт тавьж ажиллахыг зэрэгцээ 20 цагийн хичээл зааж шалгалт авна.

Хос мэргэжлээр 12 хүн, ерөнхий боловсролоор 6 хүн шат ахиж, 10 хүн утсан хөгжим тоглодог болно.

Сургуулийн насны хүүхдийн бүртгэлийн гаргаж сахилга, сурлагаараа хоцорч байгаа хүүхдийн элэг, эхэд зөвлөлтөө өгч байна.

Хөдөлмөрийн багаж хэрэгсэлд өөрсдийн хуучир урсгал засвар 2-3 удаа хийж, осол гэмтлээс урьдчилан сэргийлсэн зурагт хуудас 15 ширхэгийг гаргана.

Хөдөлмөр хамгааллын 3 шатны зааварчлагыг бүх ажилчдад тогтмол өгч холбогдох бүртгэлийг хөтөлнө.

Эмэгтэйчүүд насанд хүрээгүй хүмүүсийн хөдөлмөрийн зохицуулалт, ажлын байрны гэрэлтүүлэг, агааржуулалт, дуу доргио, цэвэр халуун хүйтнийг дүрэм зааврын дагуу тохируулж ажлын тусгаа хувиас, сүү, хамгаалах хэрэгслийн олголттой байнгын хяналт тавьж 14 хоногт 1 удаа үзлэг явуулна.

Бүлгийн хамт олон

АНГИ ДЭВШИХ БА ТӨГСӨХ ШАЛГАЛТАНД САЙН БЭЛТГЭЭ

Манай орны ерөнхий боловсролын сургуулийн анги дэвших төгсөх шалгалт эхлэхэд нөөхөн хоног үлдээд байна.

Аймгийн ардын боловсролын нийт байгууллага МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс «Ерөнхий боловсролын сургуулийн системийг наашид хөгжүүлж, сургалтын чанарыг сайжруулах арга хэмжээний тухай» тогтоолыг амьдрал практикт хэрэгжүүлэн биелүүлэх ажлыг сургуулиудын жилийн эцсийн шалгалтанд бэлтгэх ажилтай хослуулан зохиож байна.

Аймгийн хэмжээгээр өнгөрсөн хичээлийн жилд 12000 гаруй сурагчид шалгалдаж 93,1 хувийн сурлагын амжилт үзүүлсний 33,6 хувийг онц ба сайн, 66,4 хувийг дунд, муу эзэлж байв.

Нийт 868 сурагч анги улирсны дотор 441 нь 1-3 дугаар анги, 427 нь 4-8 дугаар ангийн сурагчид байлаа.

1972-1973 оны хичээлийн жилийн эцсийн дүнг урьд жилийн хичээлийн жилийн эцсийн дүнтэй харьцуулахад 1,6 хувиар буурчээ.

Энэ нь сургалтын арга нийт сургуульд жигд биш байгааг харуулах баримт мөн.

Нөгөө талаар багш нарын мэдлэг, заах аргаас шалтгаалж байна.

Багш нартай ажиллах тэдний ажлыг оновчтой зохион байгуулж удирдах хичээл тус бүрийн хөтөлбөрийн биелэлтэнд сургуулийн захиргаанаас тавьж хяналт хангалтгүй байгааг хөдөлгөөнт юм.

Энэ бүхнээс дүгнэлт хийж жилийн эцсийн шалгалтанд шаргуу сайн бэлтгэх нь анги улирч сургууль завсардах явдалыг багасгахад чухал ач холбогдолтой учир сургууль боловсролын байгууллагын гол зорилт нь сурагчдыг шалгалтанд амжилттай бэлтгүүлж, жилийн туршид үзсэн зүйлийг бат тогтвортой ойлгуулж, сургуулийн үйл ажил, багш сурагчдын оюуны хөдөлмөрийн үр дүнг дэс дараалалтай дүгнэхэд чиглүүлбэл зохино.

Үлдэж байгаа хугацааг үр дүнтэй ашиглан, анги дэвших төгсөх шалгалтанд зориулж сурагчдын урьд үзсэн хичээлийн сэдэв бүрээс судалгаа дүгнэлт хийж, сурлагаар хоцорч яваа сурагчдад туслах ажлыг сайн зохиож хэрэгтэй.

Сургуулийн дэргэдэх нам, олон нийтийн байгууллага, багш бүр сурагчдыг шалгалтанд бэлтгүүлж байгаа ажлын явцтай танилцаж зохих заавар зөвлөлтөө өгөх, анги дэвших төгсөх шалгалтын ач холбогдлыг энэг, эх сурагчдад өргөн сурталчилж шалгалтын зааврыг таниулах зэргээр багш

сурагчдыг шалгалтанд амжилттай бэлтгүүлэх ажлыг оновчтой сайн зохион байгуулж удирдах ёстой.

Шалгалтын үед програмт хичээлийн гол сэдвүүдийг тайлбарлах тодорхой төлөвлөгөө гаргаж, зөвлөлтөө өгөх, туршилт дүгнэлт, давтлага хийлгэх зэргээр сурагчдын сэтгэн болох чадварыг хөгжүүлэх ажлыг санаачилсан зохиовол зохино.

Сургууль бүр шалгалтанд амжилттай дүн үзүүлэхийн тулд багш, пионер, сурагчид, энэг, эх, сургуулийн энэг, эхийн хороо, албан газрын дэргэдэх энэг, эхийн зөвлөлийг тодорхой сайн ажилдуулахын хамт бүх ангиудад заагдаж байгаа хичээлийн программын биелэлтийг гаргаж заагдаагүй буюу хүнд сэдвийг дахин заагдахад дадлага сорилтын ажлыг бүрэн гүйцэт хийлгүүлэх, нийт сурагчдын шалгалтанд бэлтгэх боллоо ямар байгааг судалж тэдэнд туславал зохино.

Аймгийн Ардын боловсролын хэлтэс, сургалт заах аргын кабинетын байцаагч, мэргэжилтнүүдээс шалгалтын бэлтгэл ажлын явц, хичээлийн программын биелэлт, сурагчдын мэдэл, ойлголт, ажиллагаанд судалгаа дүгнэлт хийж, сургууль, багш нарч санамж, зөвлөлтөө өгөх зэрэг шалгалтыг амжилттай болоход тус нэмэр болохуйн ажлыг зохиох нь зүйтэй байна.

Сургуулиудын анги дэвших төгсөх шалгалтанд бэлтгэх ажлыг зөвхөн сургууль, боловсролын байгууллагын хүрээгээр хязгаарлахгүй, нам, улс, олон нийтийн байгууллага, энэг, эхийн идэвхтэй оролцоотойгоор амжилттай гүйцэтгэх бөгөөд энэ нь тэдгээрийн ачаарлын төвд байвал зохих нэг чухан ажил мөн.

Аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны Ардын боловсролын хэлтэсийн ажилтан Т. ДАНШИЯМ

ТОГ БУРИЙН ТӨЛӨӨ

Малчдын нөр хөдөлмөрийн үр дүн

Баянчандмань хорооны нам, захиргааны байгууллага малын зүй бүс хорогдолтой тэмцэх зарим арга хэмжээний тухай тогтоол болон Цэдэнбал даргын албан даатгалыг биелүүлэх талаар зохион байгуулалтын нийтэд арга хэмжээ авсна дүнт төл бойжилт 102 хувьтай өнгөрсөн оны мөн снийхээс малын зүй бүсний хорогдол 55 хувь буурч малын арчилгаа малаагаа сайжирч байна.

Мал фермын хэмжээгээр тугал бойжилт 98,7 хувь, 1368 хонгноос 1410 хурга, 55 ямаанаас 64 нийг бойжуулан авсны дотор аймгийн АХ-ын депутат Сономванчиг ахлагчтай суурь 100, үнээнээс 100 тугал,

намын гиншүүн хорооны депутат Дэлэгмаа 497 хонгноос 520 хурга, Сугар ахлагчтай суурь 457 хонгноос 472 хурга, адуучин Пэрэнлэйнсүндэв 61 гүүнээс 61 унага бойжуулсан дүнгээр хамт олноо хоншуулан манайтж явна. Ханаржазнуудад усалтыг буй болгох, бууцлох, өвөлжөө, хаваржааны жижиг засвар хийх, ихэр төлүүд, гунжин үнээ зусаг бог малыг тусгайлан тэжээх, хурга махлуудыг зэрэг ажилд эмч, зоотехникч нарын хүчийг дайчлан төлийн штабаас байнгын удирдлагаар хангаж олсон амжилтаа бататгах зорилттой ажиллаж байна.

Б. ПҮРВЭЭ

Саяхан түүхий эд материалын зарцуулалт ашиглалт нормчлолд нийтийн үзлэг шалгалт явуулах аймгийн комисс, АХИХ хороо, төлөвлөгөөний комисс хамтран ойн аж ахуй, хөвдлийн үйлдвэр, Барилга угсралтын контор, НААУГ, Хүнсний комбинат зэрэг үйлдвэр аж ахуйн газарт шалгалт хийв.

Үзлэг шалгалтын дүнгээс үзэхэд аймгийн НААУГ түүхий эд материалын зарцуулалт ашиглалт нормчлолд хийх нийтийн үзлэг шалгалтанд бэлтгэх тухай хариуцлагатны зөвлөлтөөнөөр хэлцэж анхан шатны бүртгэлийн маягт 19-ийг шинээр хөтлүүлж складын бараа материалын хадгалалт хангаалалтыг сайжруулах ажил зохиожээ.

Түүхий эд материалын 1973 оны зарцуулалтын тооцоо судалгааг гаргаж орцын нормгүй үйлдвэрлэж байгаа зарим бүтээгдэхүүнд шинээр норм тогтоох санал боловсруулан системийнхээ дээд байгууллагат тавьж, үйлдвэрийн түүхий эд материалын өөдөс хаягдлыг ашиглах 6 хүний бүрэлдэхүүн-

тэй бригад байгуулан ажиллаж 10,3 мянган төгрөгийн хуримтлал оруулсан зэрэг ажлын сайн эхлэлт гарчээ.

Гэвч аймгийн Ой аж ахуйд түүхий эд материалын 45,4 хувь нь нормчлогдоогүй 1973 онд зарцуулалтаас хэмнэсэн хэтрэсэн материалын тооцоог гаргаагүй. Хөвдлийн үйлдвэрт 1974 онд шинээр батлагдсан материал зар-

Хүнсний комбинат 1958-1962 онуудад техникийн нөхцөл тогтоосон зарим бүтээгдэхүүнд улсын стандарт одоо хүртэл тогтоогүй, хайрцаг хадагтанд батлагдсан бич хэмжээний хадаас хэрэглэж байгаагаас 1 хайрцагт орох хадаасыг 5,5 граммаар хэтрүүлэн хэрэглэжээ.

Иймд дээрхи үйлдвэр аж ахуйн газруудын нам, олон нийтийн байгууллага

ҮЗЛЭГ ЯВАГДАЖ БАЙНА

цуулалтын нормыг мөрдөж эхлээгүй 1973 оны хэмнэсэн ба хэтрүүлж зарцуулсан материалын тооцоо тодорхойгүй байв.

Аймгийн Барилга угсралтын конторын захиргаа, түүхий эд, материалын зарцуулалтанд шалгалт хийх төлөвлөгөөг биелүүлэх тодорхой ажил зохиогоогүй, ерөнхий инженер Баатар, эдийн засагч Чулуун, ня-бо Насанжаргал нар үзлэг шалгалтын төлөвлөгөөгөөр хариуцуулсан 10-аад төрлийн ажлаас нэггүй хийгээгүй байна.

материал зарцуулалт, ашиглалт нормчлолын ажилд оршиж байгаа эдгээр дутагдлыг түргэн хугацаанд засах талаар төлөвлөсөн зүйлүүдээ хэрэгжүүлэх шуурхай арга хэмжээ авч ажиллавал зохино.

Мөн батлагдсан нормчлолыг үйлдвэрлэлд бүрэн нэвтрүүлэн түүний гүйцэтгэлийг цаг тухайд нь бүрэн үзүүлэлтээр зөв тооцож байх, материалын нормчлолыг боловсруулж болгохын тулд үйлдвэр аж ахуйн газруудын эдийн засагч санхүү бүрт-

мянган толгойгоор нэмэгдүүлэх үүрэг амлалт аваад ажиллаж байна. Одоо 31 мянга гаруй мал төлөн, 32 мянган төл хорогдолгүй бойжиж 935 ихэр төлөтэй, төл бойжуулах төлөвлөгөө 100,2 хувьтай байна.

Д. ДОРЖСҮРЭН

Дэлгэрхаан сумын хоньчин Адъяа, Довчин, Гэлэнхүү, Бат-очир, Дорж, А.Осорхүү нар 5—10 ихэр төлөтэй, төлөө 101—101,5 хувь бойжуулж ихэр төл эзнээ баясгана гэсэн цагтлан дарцаг 3 удаа аваад байна.

Ш. ЧҮЛТЭМДАРЖАА



Бүрэн сум—нэгдлийн «Хайрхан» бригадын хоньчин МАХН-ын гишүүн О. Пагванайдангийн суурийнхан энэ жил 387 хонь, 27 ямаа төлүүлэхээс 374 хонь, 26 ямаа төлүүлээд, гарсан төлөө 2 ихэртэйгээр бүрэн мөнд бойжуулж байна.

ЗУРАГ ДЭЭР: Тус суурийнхан хонь хургаа ялгаж байгаа нь.

Б. ТОГООХҮҮ-гийн авсан гэрэл зурал

СУРАГЧИД ТӨЛЧДӨД ТУСЛАВ

Жаргалантын САА-н 10 жилийн дунд сургуулийн хэл бичгийн багш Цэдэнбалжирын хариуцсан 5-ын «А» ангийн болон бөхийн секцийн сурагчид, төлчдөд туслах аялал зохиов.

Аялалын сурагчид сургуулийн пионер сурагчид цуглуулсан нэмнээ 27, эггэвч 150 гаруй, хурганы уут 12, мөн пайз зэргийг, морьтой явган холимог аялаар 20-иод км газар явж өөрийн сургуулийн шөф. Сээрэнгийн суурьт өгөв.

Бас бууц малтаж, хөрзөн ховхойж зөөв. Энэ ажилд 5 дугаар ангийн сурагч Хандсүрэн, Отгончимэг, Энхмандах, бөхийн секцийн сурагч Рэнцэнням, Жаргалсайхан, Нэргүй нарын олон сурагч идэвхтэй оролцлоо.

Ер нь энэ сургуулийнхан төл бойжуулалт тарианогоо хураалтын үеэр шөф суурь малчид, тариаланчдад тусладаг сайхан уламжлалтай юм.

Д. БАДАРЧ

С. НАРАНЦЭЦЭГ

ЭНХ ТАЙВНЫ ТАЛЫНХАНЫ АНХДУГААР ИХ ХҮРЛЫН 25 ЖИЛИЙН ОЙД

Энх тайван—бүх нийтийн хэрэг

Дэлхийн энх тайвны талынхны анхдугаар их хурал Парис хотноо 1949 оны 4 дүгээр сарын 20—25-нд «Энх тайван бүх нийтийн хэрэг» уриан дор хуралдаж нийт 72 орны 2000 гаруй төлөөлөгчид оролцжээ.

Энэ бол «Хүйтэн дайн» ид өрнөн, НАТО-гийн түрэмгий эвсэл байгуулж байсан үе байв. Их хурал

дэлхийн улс түмнийг энх тайвны төлөө тэмцэлдээ нэгдэн нигтарч, сонор сэрмжтэй байхыг уриалсан тунхаг гаргаж, энх тайвны олон улсын шагналыг батлаж, энх тайвны талынхны их хурлын байнгын хороог байгуулж анхны ерөнхийлөгчөөр нь Францын алдарт эрдэмтэн Фредерик Жюлио Кюриг сонгожээ.

Дайн дэлхийн энх тайвны байдлын төлөө нийтийн тэмцэлд улс төрийн ба шашны үзэл бодлоороо адилгүй, янз бүрийн нам, ангийн сая сая хүмүүсийг нэгтгэх ажлыг гүнзгий гүтгэлэг, харгис цагдаагийн мөрдлөгийн хэцүү нөхцөлд зохион байгуулсан юм. Парисын их хурал дээр Ю. Жюлио Кюри: «Бид энд дайны хэнээтнүүдээс энх тайвныг гүйхын тулд цуглаагүй, харин тэднээр энх тайвныг тогтоолгохын тулд цуглаад байна» гэж хэлсэн энэ үг

энх тайвны талынхны хөндлөгөөний мөн чанарыг харуулж байна.

Дэлхийн энх тайвны талынхны хөдөлгөөн анхдугаар их хурлаасаа хойш яруу алдарт их замыг туулж ирэв. Зэвсэглэлийн хорогдуулахын төлөө, нийгмийн янз бүрийн байгуулалтай улсууд энх тайвнаар зэрэгцэн оршихын төлөө түгээмэл кампанийн нэг хэлбэр бол цөмийн зэвсгийг цаазлан хориглох тухай Стокгольмийн уриа, атомын дайны аюулын эсрэг таван их гүр-

ний энх тайвны гэрээ байгуулах тухай урианд дэлхий дахины хэмжээгээр гарын үсэг зурруулсан ялдал бөгөөд эдгээр кампанийн үед 600 сая орчим хүн гарын үсэг зурсан нь энх тайвны талынхны хүчин чадлыг илтгэн харуулсан юм.

Өнгөрсөн онд Москва хотноо болсон энхийг эрхэмлэгч хүчний их хурал нь бат эхэнх тайван тогтоох тэмцэлд асар их хувь нэмэр оруулав.

З.ТӨМӨР-ОЧИР



Хүн төрөлхтний түүх эрин үед энх тайванд ашигтайгаар өөрчлөгдсөөр байна.

Социалист ЭХХТ Зөвлөлийн орнууд дэлхийн бөмбөрцөгний хүн амин 10 хувь, газар нутгийн 19 хувийг эзлэх атлаа бүх дэлхийн аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 36 хувь, ХАА-н нийт бүтээгдэхүүний 50 шахам хувийг үйлдвэрлэн гаргаж 1 хүнд ноогдох бүтээгдэхүүнээр өндөр хөгжилтэй капиталист орнууданхаас 3 дахин илүү байгаа нь социалист хамтын нөхөрлөлийн орнуудын хөгжлийн хурдац хичнээн түргэн байгаагийн тод жишээ мөн.

Дэлхий дахины хувьсгалт үйл явцад аялчдын ангийн манлайлах роль улам өсөн нэмэгдэж, нар хүрээ өргөжиж.

Капиталист орны доторхи ажлаачин ангийн тэмцэл сүүлийн 20 жилд 3 дахин өсчээ.

СҮҮЛИЙН ҮЕИЙН БАЙДЛЫН ТОЙМ

Үүний хамтаар үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл улам бүр өрнөж, дэлхийн II дайны дараагийн 20 гаруй жилд 85 улс орон тусгаар тогтнолоо олж, капиталист бус хөгжлийн замаар хөгжиж байна.

Зөвлөлт төрийн Лениний гадаад бодлого дээр үндэслэн Зөвлөлтийн энх тайвны программыг социалист хамтын нөхөрлөлийн орнууд амжилттай хэрэгжүүлж байгаагийн үр дүнд манай гариг дээр олон улсын түгшүүртэй байдал намжиж, дайны голомтыг арилгах сайхан нөхцөл бүрэлдэж буйг Энэтхэг, Хятадын хойг, Ойрхи дорнодод гарсан бодит байдал гэрчилж байна.

Одоогоос нэг жилийн өмнө Японы нийслэл Вьетнайд энх тайвны байдал тогтоож, үндэсний нэгдлийг хангах хэвлэлээр гарин үсэг зурсан юм.

Энэ бод Вьетнайд дайныг зогсоох Парисын хэлэлцээрийн дараа гарсан улс төрийн чухал үйл явдал юм.

Үүний үр дүнд Энэтхэг, Хятадын хойгт энх тайвны байдал сэргээн тогтоход маш чухал нөлөө үзүүлэв.

Үүнээс хойш Лаос дайны гал зогссон бөгөөд өнгөрсөн 10 хоногт Хуантайз Суванна Фума тэргүүтэй үндэсний нэгдлийн түр засгийн газар, Хуан-тайз Суфандонг даргатай үндэсний улс төрийн зөвлөдөх зөвлөл байгуулсныг зарлав.

Энэ зөвлөл байгуулагдсан нь тус орны ард түмэн энх тайвны тусгаар тогтнол, үндэсний зохицол тогтоох талаар чухал алхам хийснийг нотлож байна.

БНӨВУ-н хувьсгалт түр засгийн газрын гаргасан 6 зүйлт саналыг дэлхий дахины шударга улс түмэн өргөн дэмжиж, Сайгоны дэглэмийн харгис өдөөн хатгалгыг шийдвэртэй эсэргүүцэж байна.

Гэтэл Сайгоны эрх баригчид Парисын хэлэлцээрийг ноцтой зөрчиж, Америкийн империалистууд сайгоны засаг захиргаанд нэрэг зэвсгийн тусламж үзүүлсээр байгаа

нь энэ районд энх амгальд н байдал тогтооход аюул занал учруулж байна. Үүнийг 4 дүгээр сарын эхний 10 хоногт Стокгольмд болсон олон улсын бага хуралд оролцогчид эрс эсэргүүцэн сайгоны талаас Парисын хэлэлцээрийг биелүүлэхийг эрс-шийдвэртэй шаардахыг дэлхийн олон нийтэд уриалжээ.

Энэтхэгийн далайн Диего Гарсиа аралд цэргийн бааз байгуулах гэсэн империалист гүрнүүдийн оролдлогыг эсэргүүцсэн олон улсын өдрийг Дэлхийн Энх тайвны зөвлөлийн уриалгаар 4 дүгээр сарын эхний 10 хоногт манай гариг даяар зохиолоо. Энэ өдрүүдэд дэлхийн түг түмэн шударга улс түмэн империалистуудын дайн түрэмгийлэлийн хорт төлөвлөгөөг дахин илчилж, Энэтхэгийн далайн сав газрыг энх тайвны бүс болгохын чухлыг заажээ.

Израилийн дайнчид хөрш гэрэлдээ Арабын нэгдсэн улсуудын эсрэг хийж байгаа зэвсэгт

өдөөн хатгалгаа үргэлжлүүлсээр байна.

Бүр саяхан 4 дүгээр сарын 14-ний өдөр их буу, онгоцоор дэмжүүлсэн израилийн цэрэг Ливаны нутаг дэвсгэр руу ширүүн дайралт хийв.

Мөн Сири Иорданий нутагт бараг өдөр бүр буудан, өдөөн хатгалга хийсээр байна.

Израилийн түрэмгийлэгчдийн эдгээр өдөөн хатгалгааг бүх дэлхийн шударга хүмүүс жигшин буруушааж Арабын ард түмний тэмцлийг дэмжиж байна. Одоо Израилийн дотор улс төрийн хямрал улам гүнзгийрч байгаа юм. Тэд үүнээсээ гаргахын тулд маш нууц байдалд танхимийн хуралдаан хийсэн нь бүтэлгүй боллоо.

Энэ 4 дүгээр сарын 9-ний өдөр Израилийн ерөнхий сайд Голда Меир огцорсон тухайгаа зарлав.

Израилийн цэрэг улс төрийн чиг шугамын хямралын уршгаар засгийн газарт гарсан ноцтой санал зөрөлдсөнийг зохицуулах гэсэн бүх оролдлого нь баглан унаснаас Голда Меир ийм шийдвэр гаргажээ.

Д.ДУЛАМЖАВ

ШАГНАЛ ГАРДУУЛАА

Баяндэлгэр сумын төвд 1973 оны бүх ард түмний социалист уралдаанд шалгарсан зарим тэргүүний сайчуудад шагналыг гардуулах цуглаан боллоо.

Засгийн газрын хүндэт жуух бичгээр «Байдал» бригадын хоничин Н.М.Гасар, нүүдлийн кино механикч, аймгийн 3 удаагийн аварга Д.Доржго-ч оо, ерөнхий на-бо Д.Жамсран нарын 4 хүн, МХЗЭ-ийн Төв Хорооны «Тэргүүний тариаланч залуу» алтан медалиар тракторч-комбайнч Б.Балар, Г.Лувсандорж, нарыг шагнасныг аймгийн ХЗЭ-ийн хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга П.Жанчив гарлуулав.

Мөн ургамал төлөвлөгөөг амжилттай биелүүлсэн учир аймгийн ХААУ газрын мөнгөн шагнааар Намын хорооны нарийн бичгийн дарга Д.Цэрэнхүү, ҮЗ-ийн зөвлөлийн дарга Должинсүрэн нарын 8 хүн, сумын ХЗЭ-ийн хороо 1973 ойд аймгийн эвлэлийн байгууллагуудын дунд зарласан социалист уралдаанд 1 дүгээр байр эзлэн аймгийн ХЗЭ-ийн хорооны нийслэл явах туг, баанын бичгээр, ХЗЭ-ийн хорооны нарийн бичгийн дарга Н.Халзанхүү аймгийн ХЗЭ-ийн хорооны зарлааар ЗХУ-д жуулчлах эрхийн бичгээр шагнасныг гардууллаа.

Ч.МАНУУШ

Багш нарын зөвлөлгөөний өмнө

Хоёр багшийн ажлаас

Товийн 10 жилийн дунд сургуулийн хуын-биологийн багш намын гишүүн Ч.Гажийс МНС-ийг төгсгөөд 15 дахь жилдээ ажиллаж байна.

Энэ хугацаандаа 1 удаа 10 дугаар анги, 4 удаа 7 дугаар анги, 100 хувийн дүнтэй төгсгөжээ.

Одоо энэ багшийн хариуцсан 9-ийн Б анги уулсрал дараалан 100 хувь сүрч байна.

Гажийс багш ангидаа сурлагаар хоцрогсод туслах шуурхай гуримийг 8 суралчийн бүрэлдэхүүнтэй байгуулан өдөр тутам ажиллуулж байна.

Мөн ангийнхаа суралчдын дунд дагалтын хоёр хэсэг байгуулан хооронд нь уралдаантай ажиллуулж дүн 7 хоногээр гаргаж сул сурлагатай суралчийг дээрхи гурим хүдээн явч ажиллалаг байна. Багш Гажийс ер нь амарч үед хүүхдээс хондиролгүй сэтгэхүйг хөгжүүлэхийн тулд олон төрлийн ажлууд зохион явуулдаг.

Суралчдын хооронд нь халд уралдаантай ажиллуулдаг ба түүнээс хамин хүснэгтээр дүгнэн нарийн судалгаа хөтөлжээ.

Эдний анги соёл нөлөөлд байгуулаад ажиллаж буйгаа бөгөөд 13 дугаар баазын Өвгөндүү ахлагчтай СХТБ-тай шөгийн холбоо тогтоон тэднийг ерөнхий боловсро-

лын талаар шат ахиулахад туслаж байна.

Гажийс ахлагчтай багш нарын СХБ-ын хамт олон 30 гаруй хүнийг ерөнхий боловсролын талаар шат ахиулжээ.

Төвийн 8 жилийн дунд сургуулийн бага ангийн багш Д.Гансүх өөрийн ангидаа хэлбичгийн хичээл дээр тайлбартай дасгалын арга, тооны хичээл дээр цөөн минутын бичгийн ажил хийдэг заншилтай байсан боловч ба олоот уралдааныг хүүхдэд бүр дээр 7 хоногээр дүгнэж хамин хүснэгт хөтөлж байна.

Хичээл дээр жишээ сонгож авахдаа амьдрал практикт нийт холбогдлын дээр суралчдад нэг бүрчлэн тарааж өгөх материалыг өргөн хэрэглэж байна. Мөн ангийн суралчдын талаар 12 төрлийн судалгаа, тэмдэглэл хөтөлжээ.

Эдний анги сурлага, хүмүүжл бүхий д талаараа сургууль дээрээ тэргүүн анги болжээ.

Ангийн суралчид нь улирал дараалан 100 хувь суралчийн дээр 36 суралчийн 24 нь онц ба сайн суралцаж онц сайн эзлэх хувь 63,7-д хүрсэн байна. Энэ хоёр багш зөвлөлгөөн угтсан ажилдаа ийнхүү гараа сайтай байна.

Ч.ДОРЖГОЧОО



Зуунмод хотын ХЗЭ-ийн хороо, МХЗЭ-ийн үүр, хороодын нарийн бичгийн дарга нарын улсын зөвлөлгөөн, монголын залуучуудын IV тойрон аялал угтаж Улаанбаатар хотын авто засварын завод, төмөр замын илчт тээгчид ий депогийн ХЗЭ-ийн хороодтой хамтран туршлага судлах уламжлалт тойрон аялалаа 3 дахь удаагаа зохион явууллаа.

Уулзалт тойрон аялалд оролцогчид эвлэлийн ажлын туршилагатай танилцаж Улаанбаатар хотын музей үзэж, Сүхбаатарын партизан цэрэг хүрээг чөлөөлсөн замаар аялж Зуунмодны аман

ТУРШЛАГА СУДЛАХ ТОЙРОН АЯЛАЛ

дахь байгалийн музей үзэж биеийн тамирын нөхөрсөг уулзалт тэмцээн зохиов.

Уламжлал болон зохиогддог туршлага судлах тойрон аялалын хугацаанд Зуунмод хотын ХЗЭ-ийн хороо шеф хоёр хорооноосоо ажил мэргэжлийн уралдаан, гэр бүлийн зөвлөлгөөн, урлаг спортын чуулга уулзалт зохион явуулдаг, тэргүүний үүр шалгаруулдаг зэрэг тэргүүн туршлагыг нэвтрүүлж ажилласны үр дүнд гишүүдийн манлайлал дээшилж идэвх нь өрнөж ХЗЭ-ийн үүрүүдийн ажилд тодорхой ахиц гарч байна.

Л.ЭНХТӨР

ХАРИУЦЛАГАТАЙ ЭРХЛӨГЧ

Д.ТОВУУ

ЗАРЛАЛ

Батсүмбэр сумын харьяат Чоймчиг овогтой Дагвадорж нь 308601 тоот иргэний үнэмлэхээ, Баянцогтын САА-н трактор комбайнч Зэвэгийн Цэрэндэндэв нь трактор комбайны жолоочийн 8865 номерын үнэмлэхээ тус тус гээгдүүлсэн т у л хүчингүйд тооцов.

Зуунмод хотын ОСГ-ны 7 дугаар хорооны харьяат Сундуйн Занаа, Лхамжавын Баараа нар гэрлэлтээ цуцлуулахаар сэдсэн өргөдлийг нүүдлийн 1 дүгээр шүүх хянаж байна.